

**“Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2016 оны 03 сарын**

**худалдан авалтад хийсэн аудитын дүгнэлт**

Тайлант хугацаанд “Монголын төмөр зам” ТӨХК-д

Нээлттэй тендер шалгаруулалт-1

Харьцуулалтын аргаар-0

Шууд худалдан авалт-25 хийгдсэн байна.

Үүнд:

1. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар хийгдсэн худалдан авалтын тухайд

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2016 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу суурин болон зөөврийн компьютер, дуу хураагуур, зургийн аппарат зэрэг техник хэрэгслийг худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар хийхээр Гүйцэтгэх захирлын 2016 оны 2 сарын 15-ны өдрийн А/10 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хороо 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээс АЗ сертификат бүхий компанийн 3 ажилтан, үнэлгээний хорооны байгууллагын 2 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулсан байна. Үнэлгээний хорооны гишүүд “ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай” мэдэгдлийн хуудсаар ашиг сонирхлын ямар нэг зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн. Нээлттэй тендерийг журмын дагуу зохион байгуулж 5 байгууллага оролцсноос багц-1-д “Ай Ти Зон” ХХК, багц-2-д “Саммит Компьютер технологи” ХХК тус тус сонгогджээ.

мян.төг

№	Бараа, ажил үйлчилгээний нэр	Өртөг			Гүйцэтгэгч	
		Төсөв	Гүйцэтгэл			
			Төлбөр хийгдсэн	Төлбөр хийгдээгүй		Хэтрэлт/+/ хэмнэлт -/-
1	Багц-1 Суурин компьютер-30ш	45,000		35,659.8	-9,340.2	“Ай Ти Зон” ХХК
	Багц-2 Зөөврийн компьютер-17ш, дуу хураагуур-5ш, зургийн аппарат-2ш	33,150		26,058.8	-7,091.2	“Саммит Компьютер Технологи” ХХК
	<b>Дүн</b>	<b>78,150.0</b>		<b>61,718.6</b>	<b>-16,431.4</b>	

Тайлбар: Нээлттэй тендер шалгаруулалтаар хийгдсэн худалдан авалтын багц-1 нь төсөвт өртгөөс 9,340.2 мян.төг буюу 20.7%-ийн хэмнэлт гаргасан бол багц -2-ийн тухайд 7,091.2 мян.төг буюу 21.4% -ийн хэмнэлт тус тус гаргаж нийлбэр дүнгээрээ төлөвлөгөөт үнээс 16,431.4 мян.төг буюу төсвийг 21%-иар хэмнэж чадсан үзүүлэлттэй байна.

2. Шууд худалдан авалтын тухайд

Шууд худалдан авалтууд нь 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнд хамаарахааргүй худалдан авалтууд байв.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1 д заасан босго үнийн дээд хязгаарыг зөрчөөгүй, 3 худалдан авалт нь ХО-ын төлөвлөгөөний дагуу хийгдсэн бусад нь шинэ оффист нүүж орсон тохижилтын ажилд болон албан хэрэгцээнд зориулагдан хийгдсэн төсвөөс гадуурх жижиг худалдан авалтууд хийгдсэн байна.

мян.төг

№	Бараа, ажил үйлчилгээний нэр	Өртөг				Гүйцэтгэгч
		Төсвөөрх	Гүйцэтгэлээрх		Хэтрэлт/+/ хэмнэлт /- /	
			Төлбөр хийгдсэн	Төлбөр хийгдээгүй		
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу хийгдсэн худалдан авалт						
2	ЗИОУ холбооны гэрээний загвар, эмхэтгэл, заавар	1,500	0	0	-1,500	Бэлэглэсэн
	Чөлөөт худалдааны бүс гарын авлага	489,9	489,9		-	“МТ экспресс” ХХК
	Гаалийн татварын бодлоготой гарын авлага	249	249		-	“МТ экспресс” ХХК
	<b>Дүн</b>	<b>2,238.9</b>	<b>738.9</b>		<b>-1,500</b>	

Тайлбар: 1.2016 оны 3 дугаар сард төлөвлөгөөт худалдан авалтийн төсөвт үнэ 2,238.9 мян.төгрөг байгаагаас гүйцэтгэлээр 738.9 мян.төгрөг болж 1,500 мян.төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

Боловсруулсан: дотоод аудитор

Д.Болормаа



